



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ХАЛААЛТЫН
ЗАРДЛЫН 2017-2020 ОНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ,
ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: БӨА-2021/03/ШТА-ГА

ТӨВЛӨРСӨН ХАЛААЛТАД ШИЛЖСЭН ЗАРИМ СУМУУДЫН ҮНЭ ТАРИФ ХАЛААЛТЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ ХИЙГДЭХЭД НӨЛӨӨЛСӨН БАЙНА

Баян-Өлгий аймаг 2021 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 цахим хуудас:

Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 цахим хуудас:

jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301

Цахим хуудас: nazguld@audit.gov.mn

Аудитор У.Ербол

Утас: 99425121

Цахим хуудас: erkebulankh@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, графикийн товъёог.....	4
Хавсралтын товъёог.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	6
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	8
БҮЛЭГ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017-2020 ОНЫ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ ХИЙГДСЭН БАЙНА.....	8
1.1 Халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт үндэслэлгүй, үр ашиггүй байна.....	8
1.1.1 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийг төлөвлөх, хуваарилах бодлого чиглэл тодорхойгүй байна.....	8
1.1.2 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, хуваарилалт оновчгүй байна.....	9
1.1.3. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайг хянаж баталгаажуулаагүй байгаа тул үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй байна.....	17
1.2. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн зарцуулалт, гүйцэтгэл үр ашиггүй байна.....	19
1.2.1. Халаалтын зардлын төлөвлөлт үндэслэлгүй батлагдсанаас шалтгаалж зарим төсөвт байгууллагууд 2020 оны эцэст 416.6 сая төгрөгийг өртэй байна.....	19
1.2.2. Санхүү төрийн сангийн хэлтсээс халаалтын зардлын төсвийн гүйцэтгэлд үр ашигтай хяналт тавьж ажиллаагүй байна.....	21
БҮЛЭГ 2. ХАЛААЛТЫН ҮНЭ ТАРИФ, ГЭРЭЭ ҮНДЭСЛЭЛТЭЙ, ҮР АШИГТАЙ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА.....	23
2.1. Аймгийн дулааны эрчим хүчний үнийг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа үр нөлөөгүй байна.	23
2.1.1. Зохицуулах зөвлөл сумуудын халаалтын үнэ тарифыг үндэслэлгүй тогтоосон байна.....	23
2.1.2. Төсөвт байгууллагуудад халаалт өгөх хугацааг төсөвтэй уялдуулах шаардлагатай байна.....	25
2.2. Сумуудын нэгдсэн халаалтын сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна.....	26
2.2.2. Халаалтын үнэ тарифын мөрдөлт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.....	28
Холбогдох байгууллагын санал:.....	30
ДҮГНЭЛТ:.....	31
ЗӨВЛӨМЖ:.....	32

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ССАЖГ	Спорт, соёл, аялал жуулчлалын газар
БОАЖГ	Байгаль орчин, ялал жуулчлалын газар
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЕБ	Ерөнхий боловсрол
МҮОНРТ	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв
Ал	Алтай
Ац	Алтанцөгц
Бн	Баяннуур
Бу	Булган
Бт	Бугат
Бя	Буянт
Дэ	Дэлүүн
Но	Ногооннуур
То	Толбо
Са	Сагсай
Ул	Улаанхус
Цэ	Цэнгэл
Өл	Өлгий
Цн	Цагааннуур

Хүснэгт, графикийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн ТЕЗ-ийн 2017-2020 оны халаалтын зардлын төсвийн төлөвлөлт	9
Хүснэгт 2	Аймгийн ТЕЗ-ийн харъяа төсөвт байгууллагуудын төвлөрсөн халаалтад холбогдсон эсэх талаар судалгаа	10-12
Хүснэгт 3	Халаалтын зардлын үнэ тарифт орсон өөрчлөлтийн талаар судалгаа	13
Хүснэгт 4	Сумуудын түлш халаалтын зардлын төлөвлөлтийг 2020 оныг 2017 онтой харьцуулсан судалгаа	14
Хүснэгт 5	Алтай, Алтанцөгц, Баяннуур сумуудын 2017-2020 оны түлш халаалтын зардлын төлөвлөлт	14-15
Хүснэгт 6	Өлгий сумын төсөвт байгууллагуудын 2017-2020 оны халаалтын зардлын төлөвлөлт	15-16
Хүснэгт 7	Дизель түлш, нүүрсний үнийн 2017-2020 онуудын судалгаа	17
Хүснэгт 8	Аймгийн ТЕЗ-ийн 2017-2020 оны халаалтын зардлын төсвийн гүйцэтгэл	19
Хүснэгт 9	Түлш халаалтын зардлын гүйцэтгэлийг аймгийн шууд төсвийн байгууллагууд болон сумуудаар ангилсан судалгаа	19
Хүснэгт 10	2020 онд шинээр үүссэн халаалтын зардлын өр төлбөрийн судалгаа	20
Хүснэгт 11	2015 оноос дамжиж ирсэн халаалтын зардлын өр төлбөрийн судалгаа	21
Хүснэгт 12	Сумуудын халаалтын үнэ тарифын талаар судалгаа	23
Хүснэгт 13	Төсөвт байгууллагуудыг халаалтаар ханган нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулалтын талаар судалгаа	24-25

Хавсралтын товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1		
Хавсралт 2		
Хавсралт 3		

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын 2017-2020 оны төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд гүйцэтгэлийн аудит хийж дүгнэлт гарган төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн.Үүнд: • Төсөвт байгууллагуудын 2017-2020 оны халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл үндэслэлтэй эсэх • Халаалтын үнэ тариф, гэрээ үндэслэлтэй, үр ашигтай хийгдсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад орон нутгийн төсвийн байгууллагуудын халаалтын зардлын 2017-2020 оны төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтыг хамруулж, төлөвлөлт, хуваарилалт хийсэн тооцоо судалгаа, ажлын тайлан, халаалтын үнэ тариф тогтоосон тогтоол шийдвэр, халаалт нийлүүлэх байгууллагуудын сонгон шалгаруулалт, гэрээний хэрэгжилт, холбогдох бусад санхүүгийн баримт материалд үндэслэн гүйцэтгэв.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан баримт материалыг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа,

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын төлөвлөгөө, хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, У.Ербол нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг 2021 оны 05 дугаар сарын 03-наас 05 дугаар сарын 14-ний хооронд хийж батлуулан, талбарын ажлыг 2021 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, баталгаажуулан 2021 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

Ковид-19 цар тахлын улмаас аудитад шаардлагатай мэдээлэл, судалгааг байгууллагуудаас хугацаанд нь авч чадаагүй, аймгийн Зохицуулах зөвлөлийн гишүүд ковид-19-тэй холбоотой тусгаарлалтанд орсон тул уулзалт хийж чадаагүй болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Тус аудитад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа аймаг, сумын нийт 131 төсөвт байгууллагыг хамрууллаа.

Аймгийн төвийн нэгдсэн халаалтад холбогдсон 34 байгууллагын 2009-2010 оны халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд 2012 онд аудит хийгдсэнээс хойш, халаалтын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд аудит хийгдээгүй байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын халаалтын зардалд 2017 онд 4079.9 сая төгрөгийн 2018 онд 4635.2 сая төгрөгийн, 2019 онд 4882.0 сая төгрөгийн, 2020 онд 5258.7 сая төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр 2017 онд 4085.9 сая төгрөгийн, 2018 онд 4609.0 сая төгрөгийн, 2019 онд 4862.1 сая төгрөгийн, 2020 онд 5132.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсөв 2020 онд 2017 онтой харьцуулахад 1178.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Ихэнх сумын төсөвт байгууллагуудыг 2017 оноос нэгдсэн халаалтад холбож, аж ахуйн нэгжүүдэд гэрээгээр гүйцэтгүүлж ирсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2017-2020 ОНЫ ХАЛААЛТЫН ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ ҮНДЭСЛЭЛГҮЙ ХИЙГДСЭН БАЙНА

1.1 Халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт үндэслэлгүй, үр ашиггүй байна

1.1.1 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийг төлөвлөх, хуваарилах бодлого чиглэл тодорхойгүй байна

Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар аймгийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрх үүрэгтэй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.8-д төсөвт байгууллагуудын халаалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сумуудыг нэгдсэн халаалттай болгох асуудлыг үе шаттайгаар судалж, шийдвэрлэхээр тусгасан байна.

2017-2020 оны төсвийн жилүүдэд төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлын төсвийг төлөвлөх, хуваарилах талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоогүй байна.

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлд аймагт эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл хэрэгжүүлэхээр заажээ.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн нар төсөвт байгууллагуудаас ирүүлсэн халаалтын зардлын төсвийн төслийг Эрчим хүчний сайдын тушаалаар тогтоосон халаалтын улирал, төсөвт байгууллагуудын

халаалтын талбай, эзлэхүүн, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан дулааны эрчим хүчний үнэ тарифыг үндэслэж хянаж, төлөвлөж ирсэн байна.

Эрчим хүчний сайдын 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 08 дугаар тушаалаар тус аймгийн халаалтын эхлэх хугацааг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр буюу 7 сар 15 хоногоор тогтоожээ.

Мөн Эрчим хүчний сайдын 2018 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 109, 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 170 дугаар тушаалаар тус аймгийн халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр буюу 8 сараар тогтоосон байна.

Эрчим хүчний сайдын тушаалыг үндэслэж аймгийн Засаг дарга төсөвт байгууллагуудын халаалтын талаар баримтлах бодлого чиглэлийг тодорхойлж зохицуулалт хийгээгүйгээс төсөвт байгууллагууд халаалтын зардлыг батлагдсан төсөвтөө багтаан гэрээ байгуулснаар халаалт авах сар харилцан адилгүй байна.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөх, хуваарилах бодлого чиглэлийг тодорхойлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

1.1.2 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төлөвлөлт, хуваарилалт оновчгүй байна

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын түлш халаалтын зардлын 2017-2020 оны төсвийг нийт дүнгээр хүснэгтээр нэгтгэж харуулбал:

Хүснэгт №1

сая төгрөгөөр

Түлш халаалтын зардлын төлөвлөгөө			
2017 он	2018 он	2019 он	2020 он
4079.9	4616.4	4871.6	5258.7
Эх сурвалж: Аудитын судалгаа			

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа 123 төсөвт байгууллагын түлш халаалтын зардалд 2017 онд 4079.9 сая төгрөг, 2018 онд 4616.4 сая төгрөг, 2019 онд 126 төсөвт байгууллагын түлш халаалтын зардалд 4871.6 сая төгрөг, 2020 онд 129 төсөвт байгууллагын түлш халаалтын зардалд 5258.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Түлш халаалтын зардлын төсөв өмнөх оны төлөвлөгөөнөөс 2018 онд 536.5 сая төгрөгөөр буюу 13.5 хувиар, 2019 онд 255.2 сая төгрөгөөр буюу 5.5 хувиар, 2020 онд 387.1 сая төгрөгөөр буюу 7.9 хувиар нэмэгдсэн байна.

2020 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн Өлгий сумын Ерөнхий боловсролын 10 дугаар сургууль, Цэнгэл сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2020 оны төсөвт түлш халаалтын зардлын төсөв тусгагдаагүй байна.

Аудитад хамрагдсан ТЭЗ-ийн харъяа нийт 131 байгууллагын 51% буюу 68 нь төвлөрсөн халаалтад холбогдсон ба 64 байгууллага энгийн халаалттай байна./Хүснэгт №2/

2020 оны эцсийн байдлаар Булган, Ногооннуур сум, Цагааннуур тосгоноос бусад бүх сумын төвийн төсөвт байгууллагууд төвлөрсөн халаалтад холбогдсон байна. Дэлүүн сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, цэцэрлэгүүдээс бусад байгууллагууд энгийн халаалттай байна.

Өлгий сумын 34 байгууллагын 10 нь төвлөрсөн халаалттай, 24 нь энгийн халаалттай байна.

Хүснэгт №2

№	Аймгийн ТЭЗ-ийн харъяа төсөвт байгууллагууд	Төвлөрсөн халаалт	Энгийн халаалт	Эрчим хүчээр хангаж буй ААНБ-ын нэр
1	Бө.Ахмадын хороо	1		Эрчим Баян-Өлгий ХК
2	Бө. ССАЖГ	1		Эрчим Баян-Өлгий ХК
3	Бө. МҮОНРТ-ийн БӨ салбар	1		Эрчим Баян-Өлгий ХК
4	Бө. Хөгжимт драмын театр	1		Эрчим Баян-Өлгий ХК
5	Бө. Өлгий. Номын сан	1		"Эрчим-баян" ХХК
6	Бө. Засаг даргын тамгын газар	1		"Эрчим-баян" ХХК
7	Бө. Өлгий. Музей	1		"Эрчим-баян" ХХК
8	Бө. Аймгийн асрамжийн газар	1		"Эрчим-баян" ХХК
9	ГХБХБГ	1		"Эрчим-баян" ХХК
10	Бө. БОАЖГ	1		"Эрчим-баян" ХХК
11	Бө. Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс	1		Ахмадын хороонд төлдөг
12	Бө. Ал. Засаг даргын тамгын газар	1		"Нур-төре" ХХК
13	Бө. Ал. Эмнэлэг	1		"Нур-төре" ХХК
14	Бө. Ал. Сургууль	1		"Нур-төре" ХХК
15	Бө. Ал. Соёлын төв	1		"Нур-төре" ХХК
16	Бө. Ал. Улаанхад бага сургууль		1	
17	Бө. Ал. Цэцэрлэг	1		"Нур-төре" ХХК
18	Бө. Ац. Эмнэлэг	1		"ТММН" ХХК
19	Бө. Ац. Сургууль	1		"ТММН" ХХК
20	Бө. Ац. Засаг даргын тамгын газар	1		"ТММН" ХХК
21	Бө. Ац. Соёлын төв	1		"ТММН" ХХК
22	Бө. Ац. Цэцэрлэг	1		"ТММН" ХХК
23	Бө. Бн. Эмнэлэг	1		Киели жүйрик ХХК
24	Бө. Бн. Сургууль	1		Киели жүйрик ХХК
25	Бө. Бн. Засаг даргын тамгын газар	1		Киели жүйрик ХХК
26	Бө. Бн. Цэцэгт бага сургууль		1	
27	Бө. Бн. Цагаан арал бага сургууль		1	
28	Бө. Бн. Хүүхдийн цэцэрлэг	1		Киели жүйрик ХХК
29	Бө. Бн. Соёлын төв	1		Киели жүйрик ХХК
30	Бө. Бт. Сургууль	1		АхниетХХК
31	Бө. Бт. Засаг даргын тамгын газар	1		АхниетХХК
32	Бө. Бт. Эмнэлэг	1		АхниетХХК
33	Бө. Бт. Соёлын төв	1		АхниетХХК
34	Бө. Бт. Хүүхдийн цэцэрлэг	1		АхниетХХК
35	Бө. Бу. Ёлт цэцэрлэг		1	
36	Бө. Бу. 1-р сургууль		1	
37	Бө. Бу. Засаг даргын тамгын газар		1	
38	Бө. Бу. Эмнэлэг		1	
39	Бө. Бу. Ёлт бага сургууль		1	
40	Бө. Бу. Соёлын төв		1	
41	Бө. Бу. Шүвтэр бага сургууль		1	
42	Бө. Бу. Цэцэрлэг		1	
43	Бө. Бя. Сургууль	1		Акбейл ХХК
44	Бө. Бя. Засаг даргын тамгын газар	1		Акбейл ХХК
45	Бө. Бя. Эмнэлэг	1		Акбейл ХХК
46	Бө. Бя. Соёлын төв	1		Акбейл ХХК
47	Бө. Бя. Хүүхдийн цэцэрлэг	1		"Ахбейл" ХХК
48	Бө. Дэ. Болашах бага сургууль		1	
49	Бө. Дэ. 2-р цэцэрлэг		1	
50	Бө. Дэ. Сургууль	1	1	Жанат ХХК

51	Бө. Дэ. Засаг даргын тамгын газар		1	
52	Бө. Дэ. Соёлын төв		1	
53	Бө. Дэ. Таван салаа бага сургууль		1	
54	Бө. Дэ. Хүүхдийн цэцэрлэг	1		Жанат ХХК
55	Бө. Но. 2-р цэцэрлэг		1	
56	Бө. Но. Чихтэй бага сургууль		1	
57	Бө. Но. Ховд бага сургууль		1	
58	Бө. Но. Улаанчулуут бага сургууль		1	
59	Бө. Но. Цэцэрлэг		1	
60	Бө. Но. Сургууль		1	
61	Бө. Но. Засаг даргын тамгын газар		1	
62	Бө. Но. Соёлын төв		1	
63	Бө. Са. Даян бага сургууль		1	
64	Бө. Са. 2-р цэцэрлэг	1		Каде ХХК
65	Бө. Са. Эмнэлэг	1		Каде ХХК
66	Бө. Са. Засаг даргын тамгын газар	1		Каде ХХК
67	Бө. Са. Сургууль	1		Каде ХХК
68	Бө. Са. Соёлын төв	1		Каде ХХК
69	Бө. Са. Хүүхдийн цэцэрлэг	1		Каде ХХК
70	Бө. То. Засаг даргын тамгын газар	1		Агайн ХХК
71	Бө. То. Сургууль	1		Агайн ХХК
72	Бө. То. Хүүхдийн цэцэрлэг	1		Агайн ХХК
73	Бө. То. Эмнэлэг	1		Агайн ХХК
74	Бө. То. Соёлын төв	1		Агайн ХХК
75	Бө. Ул. Хөх хөтөл цэцэрлэг		1	
76	Бө. Ул. Согог цэцэрлэг		1	
77	Бө. Ул. Сургууль	1		"Эрчим-баян өлгий" ХХК
78	Бө. Ул. Засаг даргын тамгын газар	1		"Эрчим-баян өлгий" ХХК
79	Бө. Ул. Цэцэрлэг	1		"Эрчим-баян өлгий" ХХК
80	Бө. Ул. Эмнэлэг	1		"Эрчим-баян өлгий" ХХК
81	Бө. Ул. Соёлын төв		1	
82	Бө. Ул. Согог сургууль 9		1	
83	Бө. Ул. Хөх хөтөл сургууль 9		1	
84	Бө. Цэ. 2-р Цэцэрлэг		1	
85	БӨ.Цэнгэл-4-р цэцэрлэг		1	
86	Бө. Цэ. 3-р цэцэрлэг		1	
87	Бө. Цэ. Засаг даргын тамгын газар	1		"Агайын" ХХК
88	Бө. Цэ. Соёлын төв	1		"Агайын" ХХК
89	Бө. Цэ. Тува бага сургууль	1		"Агайын" ХХК
90	Бө. Цэ. Сургууль	1		"Агайын" ХХК
91	Бө. Цэ. Загаст нуур бага сургууль		1	
92	Бө. Цэ. 1-р Цэцэрлэг	1		"Агайын" ХХК
93	Бө. Өл. 11-р цэцэрлэг		1	
94	Бө. Өл. 2-р бага сургууль		1	
95	Бө. Өл. 12-р цэцэрлэг		1	
96	Бө. Өл. 15-р цэцэрлэг		1	
97	Бө. Өл. 16-р цэцэрлэг		1	
98	Бө. Өл. 17-р цэцэрлэг		1	
99	Бө. Өл. 18-р цэцэрлэг		1	
100	Бө. Өл. Эрдэм цогцолбор цэцэрлэг		1	
101	Бө. Өл. 13-р цэцэрлэг		1	
102	Бө. Өл. 14-р цэцэрлэг		1	Хүлэг ирээдүй ХХК
103	Бө. Өл. 19-р цэцэрлэг		1	
104	Бө. Өл. 2-р цогцолбор сургууль		1	
105	Бө. Өл. Цэцэрлэг /Цогцолбор-2/		1	
106	Бө. Өл. 2-р цэцэрлэг	1		Эрчим Баян-Өлгий ХК
107	Бө. Өл. 3-р цэцэрлэг	1		Эрчим Баян-Өлгий ХК
108	Бө. Өл. 1-р сургууль	1		Эрчим Баян-Өлгий ХК
109	Бө. Өл. 1-р бага сургууль		1	Өлгий таван гал ХХК
110	Бө. Өл. 5-р сургууль		1	"ТММН" ХХК
111	Бө. Өл. 3-р сургууль	1		Эрчим Баян-Өлгий ХК
112	Бө. Өл. 8-р цэцэрлэг		1	
113	Бө. Өл. 6-р цэцэрлэг		1	
114	Бө. Өл. 7-р цэцэрлэг		1	
115	Бө. Өл. Хотгор цэцэрлэг		1	
116	Бө. Өл. 6-р сургууль	1		Эрчим Баян-Өлгий ХК
117	Бө. Өл. 2-р сургууль	1		Эрчим Баян-Өлгий ХК
118	Бө. Өл. Хотгор эмнэлэг		1	

119	Бө. Өл. Засаг даргын тамгын газар	1		Эрчим Баян-Өлгий ХК
120	Бө. Өл. 5-р цэцэрлэг	1		Эрчим Баян-Өлгий ХК
121	Бө. Өл. 1-р цэцэрлэг	1		Эрчим Баян-Өлгий ХК
122	Бө. Өл. 4-р сургууль	1		Эрчим Баян-Өлгий ХК
123	Бө. Өл. Хотгор бага сургууль		1	
124	Бө. Өл. 10-р цэцэрлэг		1	
125	Бө. Өл. 4-р цэцэрлэг		1	
126	Бө. Өл. 9-р цэцэрлэг		1	
	Бө. Цн тосгон. Захирагчийн ажлын алба		1	
127	Бө. Цн тосгон. Сургууль 9		1	"Нур Думан" ХХК
128	Бө. Цн тосгон. Цэцэрлэг		1	
129	Бө. Цн тосгон. Эмнэлэг		1	
130	Бө. Цн тосгон. Соёлын төв		1	
131				
	ДҮН	68	64	

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн шууд санхүүждэг болон Өлгий сумын төсөвт байгууллагуудыг “Эрчим” ХХК, Алтай суманд “Нур-төре” ХХК, Алтанцөгц суманд “ТММН” ХХК, Баяннуур суманд “Киели жүйрик” ХХК, Бугат суманд “Ахниет” ХХК, Буянт суманд “Ахбейл” ХХК, Дэлүүн суманд “Жанат” ХХК, Сагсай суманд “Каде” ХХК, Улаанхус суманд “Эрчим-баян” ХХК, Толбо, Цэнгэл сумуудад “Агайын” ХХК төсөвт байгууллагуудыг гэрээний дагуу төвлөрсөн халаалтаар хангаж ирсэн байна.

Өлгий сумын энгийн халаалттай 24 байгууллагаас Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийг “ТММН” ХХК, Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийг “Хүлэг ирээдүй” ХХК халаалтаар хангадаг ба бусад байгууллагууд өөрсдөө галладаг энгийн халаалттай байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, төсвийн мэргэжилтэн нар халаалтын зардлын төсвийн төлөвлөлттэй холбоотой дараах тайлбарыг ирүүлсэн.Үүнд:

“Төсөвт байгууллагуудаас ирүүлсэн төсвийн төслийг нэгтгэж, Сангийн яаманд саналыг бууруулахгүйгээр явуулж байгаа боловч жил бүр халаалтын зардал дутуу батлагдаж ирдэг. Сангийн яамнаас батлагдаж ирсэн төсвийг төсөвт байгууллагуудад хуваарилахдаа Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон үнэ тариф, сумуудын байгуулсан комиссын ирүүлсэн талбайн хэмжээ, үнэ тогтоосон тогтоолын дагуу халаалтын төсвийг хуваарилдаг.

Аймгийн Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоосон үнэ тариф болон сумын төсөвт байгууллагуудын ирүүлсэн халаалтын талбайн хэмжээг тогтоосон холбогдох баримтыг үндэслэн халаалтын зардлыг хянаж баталдаг. Сумын ажлын хэсгийн тогтоосон талбайн хэмжээг үндэслэдэг, талбайн хэмжээ өөрчлөгдсөн эсэх талаар төсвийн төсөл авах үед судалгаа авдаг” гэсэн байна.

Аудитын хугацаанд бүх сумын санхүүгийн албанаас төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүн, үнэ тариф, халаалт төлсөн хугацааны талаар судалгаа авч, дулаан эрчим хүчээр ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээ зэрэг холбогдох нотлох баримтуудыг авч шалгасан боловч ирүүлсэн баримтууд нь хангалтгүй байна. Тухайлбал:

Төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүнийг үнэн зөв хянаж тогтоосон эсэх нь тодорхойгүй, байгууллагууд халаалтын гэрээг жил бүр шинэчлэн байгуулаагүй, зарим сум төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

Төсөвт байгууллагуудын халаалтын төсөв нь шинээр барилга байгууламж ашиглалтад орж халаалтын талбай нэмэгдэх, шинээр төвлөрсөн халаалтад холбогдох, халаалтын зардал төлж байгаа хугацаа харилцан адилгүй байх зэрэг шалтгаанаас хамаарч аймаг, сумуудад харилцан адилгүй байна.

Мөн төвлөрсөн халаалтад холбогдсон сумуудын халаалтын үнэ тариф харилцан адилгүй байна.

Халаалтын зардлын үнэ тарифт орсон өөрчлөлтийн судалгаа.

Хүснэгт №3

төгрөгөөр

Аймаг, сумын нэр	Зохицуулах зөвлөлийн тогтоолын огноо		Анх тогтоосон		Нэмэгдсэн		2020.12.31-ний байдлаар мөрдөж байгаа тариф	
	Анх баталсан	Өөрчлөлт оруулсан	Төсөвт байгууллагууд	Дотуур байр	Төсөвт байгууллагууд	Дотуур байр	Төсөвт байгууллагууд	Дотуур байр
Баян-Өлгий шууд	2017		1430		122.1	0	1552	
Алтай	2017.08.01	2020.12.18	1420	1420	0	0	1420	1420
Алтанцөгц	2017.08.01	2017.08.01	1320		0	0	1320	0
Баяннуур	2018.07.27	2020.01.16	1376		0	0	1376	0
Бугат	2018.07.27	0	1298	2170	0	0	1298	2170
Буянт	2018.07.27	2020.01.16	1370	2464	0	0	1370	2464
Дэлүүн	2015.07.29	2019.09.23	1180	1350	0	0	1180	1350
Сагсай	2018.08.27	0	1320	2218	0	0	1320	2218
Толбо	2017.11.14	0	1350		0	0	1350	0
Улаанхус	2015.07.29	2019.09.23	1180	1350	0	0	1180	1350
Цэнгэл	2017.11.14	2017.12.18	1380	1420	0	0	1380	1420
Өлгий сум ЕБ-ын 5-р сургууль	2017.11.27	0	1300		0	0	1300	0
Өлгий сум 14-р цэцэрлэг	2017.11.27	0	1300		0	0	1300	0

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тогтоосон төвлөрсөн халаалтад холбогдсон сумуудын анх батлагдсан тарифт 2020 оны 12 дугаар сарын 30-ны байдлаар өөрчлөлт ороогүй байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 53 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Өлгий сумын хэрэглэгчдэд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх тарифыг НӨАТ-гүй 1411 төгрөгөөр тогтоосонтой холбоотой аймгийн шууд болон Өлгий сумын төсөвт байгууллагууд 2017 оноос халаалтын гэрээгээ НӨАТ орсон дүнгээр 1552 төгрөгөөр гэрээ байгуулсан байна.

Эрчим хүчний тухай хуулийн 27 дугаар зүйл “Тариф, гэрээний үнэ”, 27.1-д “Зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хангагчаас үзүүлж байгаа үйлчилгээний нөхцөл, үнийг жил бүр, тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдол бүрд хянана” гэж заасан боловч Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс үнэ тарифыг жил бүр хянаж байгаагүй байна.

2020 оныг 2017 онтой харьцуулахад түлш халаалтын зардал нийтдээ 1178.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнийг аймаг, сумаар задалж харуулбал:

Хүснэгт №4		сая төгрөгөөр		
Аймаг, сумаар	2017 он	2020 он	Зөрүү	
Баян-Өлгий шууд	782.9	883.2	100.3	
Алтай	98.3	277.9	179.5	
Алтанцөгц	60.9	263.1	202.2	
Баяннуур	98.0	257.9	159.9	
Бугат	77.3	128.9	51.6	
Булган	173.0	179.2	6.2	
Буянт	69.8	107.2	37.3	
Дэлүүн	306.2	350.5	44.2	
Ногооннуур	77.8	94.6	16.8	
Сагсай	185.3	267.3	82.0	
Толбо	279.7	261.5	(18.2)	
Улаанхус	364.4	338.9	(25.6)	
Цэнгэл	370.6	344.3	(26.2)	
Өлгий	1102.7	1,428.4	325.6	
Цагааннуур	32.9	75.8	43.0	
Дүн	4079.9	5,258.6	1,178.8	

Эх сурвалж: Аудитын судалгаа

Толбо, Улаанхус, Цэнгэл сумуудын халаалтын зардал 18.2-26.2 сая төгрөгөөр буурч бусад бүх сум болон аймгийн төвийн төсөвт байгууллагуудын халаалтын зардал 6.2-325.6 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Алтанцөгц сумын ТТЗ-ийн түлш халаалтын зардал 202.2 сая төгрөгөөр, Алтай сумын ТТЗ-ийн түлш халаалтын зардал 179.5 сая төгрөгөөр, Баяннуур сумын ТТЗ-ийн түлш халаалтын зардал 159.9 сая төгрөгөөр, Өлгий сумын ТТЗ-ийн харъяа байгууллагуудын түлш халаалтын зардал 325.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бусад сумуудаас өндөр байна.

Алтай, Алтанцөгц сумуудад 2017-2020 онуудад шинээр төсөвт байгууллага нэмэгдээгүй, төсөвт байгууллагуудын халаалтын талбайд өөрчлөлт ороогүй байхад түлш халаалтын зардлыг 163-332 хувиар нэмэгдүүлсэн нь Алтай сумын төсөвт байгууллагууд 2017 оны 12 дугаар сараас, Алтанцөгц сумын төсөвт байгууллагууд 2018 оны 11 дүгээр сараас төвлөрсөн халаалтад холбогдсонтой холбоотой байна.

Баяннуур суманд 2018 онд 3072 метр куб дотуур байр ашиглалтад орж халаалтын талбай нэмэгдэж, гал тогоо шинэ дотуур байранд байрласан учир 759 метр куб халаалтын талбай буурсан байна. Баяннуур сумын Цэцэгт, Цагаан-арал бага сургуулиас бусад төсөвт байгууллагууд 2019 оноос төвлөрсөн халаалтад холбогдож 2019 оноос халаалтын зардлыг нэмэгдүүлсэн байна.

Дээрх сумуудын халаалтын зардлын судалгаа.

Хүснэгт №5		сая төгрөгөөр				
Сумууд		2017 он	2018 он	2019 он	2020 он	Зөрүү /2017, 2020/
1	Ал. Засаг даргын тамгын газар	15.1	15.1	24.6	23.9	8.80
2	Ал. Эмнэлэг	10.6	30.1	30.1	28.9	18.30
3	Ал. Сургууль	50.3	183.7	110.8	174.7	124.40
4	Ал. Соёлын төв	3.6	3.6	13.2	9.9	6.30

5	Ал. Улаанхад бага сургууль	6.9	6.9	6.9	10.3	3.40
6	Ал. Цэцэрлэг	11.7	22.2	25.2	30.2	18.50
	Дүн	98.2	261.6	210.8	277.9	179.70
1	Ац. Эмнэлэг	8.1	8.1	36.3	36.3	28.20
2	Ац. Сургууль	32.4	32.4	106.6	149.9	117.50
3	Ац. Засаг даргын тамгын газар	9.7	9.7	25.2	26.4	16.70
4	Ац. Соёлын төв	3.0	3.0	21.3	10.1	7.10
5	Ац. Цэцэрлэг	7.8	6.9	35.6	40.4	32.60
	Дүн	61.0	60.1	225.0	263.1	202.10
1	Бн. Эмнэлэг	9.9	11.7	41.4	41.2	31.30
2	Бн. Сургууль	43.3	43.3	86.9	136.9	93.60
3	Бн. Засаг даргын тамгын газар	12.7	11.7	16.7	18.8	6.10
4	Бн. Цэцэгт бага сургууль	9.7	9.7	10.9	8.9	(0.80)
5	Бн. Цагаан арал бага сургууль	10.1	12.0	11.8	10.3	0.20
6	Бн. Хүүхдийн цэцэрлэг	9.2	9.2	30.8	27.8	18.60
7	Бн. Соёлын төв	2.9	2.9	19.5	14.0	11.10
	Дүн	97.8	100.5	218.0	257.9	160.10

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх сумуудын ерөнхий боловсролын ахлах сургуулиуд, эмнэлэг, цэцэрлэгүүдийн түлш халаалтын зардлын төсвийг 3-аас 4 дахин нэмэгдүүлсэн байна.

Өлгий сумын ТТЗ-ийн харъяа байгууллагуудын халаалтын зардлын судалгаа.

Хүснэгт №6

сая төгрөгөөр

№	Өлгий сумын төсөвт байгууллагууд	2017 он	2018 он	2019 он	2020 он	Зөрүү /2017, 2020/
1	Өл. 11-р цэцэрлэг	5.7	6.1	7.0	5.5	(0)
2	Өл. 2-р бага сургууль	15.8	16.8	19.2	14.2	(2)
3	Өл. 12-р цэцэрлэг	6.8	6.8	7.6	5.9	(1)
4	Өл. 15-р цэцэрлэг	5.2	5.2	6.2	5.2	0
5	Өл. 16-р цэцэрлэг	5.2	5.2	6.2	5.2	0
6	Өл. 17-р цэцэрлэг	5.2	4.5	6.2	5.2	0
7	Өл. 18-р цэцэрлэг	5.2	5.2	6.2	4.2	(1)
8	Өл. Эрдэм цогцолбор цэцэрлэг	1.0	1.0	1.0	1.0	-
9	Өл. 13-р цэцэрлэг	4.7	4.7	6.2	5.7	1
10	Өл. 14-р цэцэрлэг		21.5	22.4	20.9	21
11	Өл. 19-р цэцэрлэг			2.2	6.2	6
12	Өл. 2-р цогцолбор сургууль					-
13	Өл. Цэцэрлэг /Цогцолбор-2/				25.0	25
14	Өл. 2-р цэцэрлэг	45.1	58.5	52.4	52.5	7
15	Өл. 3-р цэцэрлэг	9.3	9.7	8.6	22.5	13
16	Өл. 1-р сургууль	135.6	190.7	173.5	163.7	28
17	Өл. 1-р бага сургууль	20.3	24.6	29.6	29.6	9
18	Өл. 5-р сургууль	57.6	57.6	87.6	82.1	25
19	Өл. 3-р сургууль	228.1	265.3	225.9	234.0	6
20	Өл. 8-р цэцэрлэг	7.9	13.2	7.9	23.4	15
21	Өл. 6-р цэцэрлэг	7.3	7.7	8.2	6.7	(1)
22	Өл. 7-р цэцэрлэг	6.7	6.7	8.2	5.7	(1)
23	Өл. Хотгор цэцэрлэг	1.7	1.7	1.7	1.7	0
24	Өл. 6-р сургууль	38.4	38.5	41.7	43.5	5
25	Өл. 2-р сургууль	173.7	329.2	276.8	290.3	117
26	Өл. Хотгор эмнэлэг	0.7	1.0	1.2	1.7	1
27	Өл. Засаг даргын тамгын газар	41.6	37.4	28.8	30.8	(11)
28	Өл. 5-р цэцэрлэг	57.1	70.8	62.0	66.4	9

29	Өл. 1-р цэцэрлэг	27.4	27.2	47.7	52.2	25
30	Өл. 4-р сургууль	162.0	212.1	197.9	187.1	25
31	Өл. Хотгор бага сургууль	2.7	2.7	3.1	2.7	0
32	Өл. 10-р цэцэрлэг	4.5	4.5	5.1	5.1	1
33	Өл. 4-р цэцэрлэг	8.9	8.6	8.6	8.1	(1)
34	Өл. 9-р цэцэрлэг	11.1	11.1	15.2	14.2	3
	ДҮН	1,102.4	1,455.7	1,382.0	1,428.3	325.9

Эх сурвалж: Аудитын судалгаагаар

Шинээр байгуулагдсан цэцэрлэгүүдийн халаалтын зардлын төсвийг тухайн жилийн төсөвт тусгаж ирсэн байна. Тухайлбал: Өлгий сумын 14 дүгээр цэцэрлэгийн төсвийг 2018 оноос, 19 дүгээр цэцэрлэгийн төсвийг 2019 оноос, 20 дугаар цэцэрлэгийн төсвийг 2020 оноос төсөвт тусган төлөвлөсөн байна.

Байрны талбайн хэмжээнд өөрчлөлт ороогүй байхад Өлгий сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн түлш халаалтын зардлыг 28.0 сая төгрөгөөр, Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн түлш халаалтын зардлыг 25.0 сая төгрөгөөр, Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн түлш халаалтын зардлыг 25.0 сая төгрөгөөр, 1 дүгээр бага сургуулийн түлш халаалтын зардлыг 9.0 сая төгрөгөөр, 1 дүгээр цэцэрлэгийн түлш халаалтын зардлыг 25.0 сая төгрөгөөр, 2 дугаар цэцэрлэгийн түлш халаалтын зардлыг 7.0 сая төгрөгөөр, 3 дугаар цэцэрлэгийн зардлыг 13.0 сая төгрөгөөр, 5 дугаар цэцэрлэгийн түлш халаалтын зардлыг 9.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн байна. Шалтгааныг тодруулахад:

-Халаалтын үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой төвлөрсөн халаалтад холбогдсон Ерөнхий боловсролын 1, 4 дүгээр сургууль, 2, 5 дугаар цэцэрлэгийн халаалтын төсөв нэмэгдсэн.

-Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан шинэ хичээлийн байранд үйл ажиллагаа явуулж эхэлсэнтэй холбоотой түлш халаалтын зардлын төсөв 117.0 сая төгрөгөөр, 1, 3 дугаар цэцэрлэгүүд түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой түлш халаалтын зардлын төсөв нэмэгдсэн.

Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн түлш халаалтын зардал 57.6 сая төгрөг байсныг 2017 оны 12 дугаар сараас төвлөрсөн халаалтын үнэ тарифаар тооцож 2019 онд 87.6 сая төгрөг, 2020 онд 82.1 сая төгрөг болгон үндэслэлгүй нэмэгдүүлсэн байна. Мөн Өлгий сумын 14 дүгээр цэцэрлэгийн халаалтыг 2018 оноос төвлөрсөн халаалтын үнэ тарифаар тооцож, зардлыг төлөвлөж ирсэн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн 3.1.11-д “төвлөрсөн дулаан хангамж” гэж дулаан, цахилгааныг хослон үйлдвэрлэдэг болон дулааныг дангаар үйлдвэрлэдэг эх үүсвэрээс диспетчерийн зохицуулалттайгаар, эсхүл төв суурин газрын нийт хэрэглээний 50 хувиас дээш хэсгийг шугам сүлжээгээр хангах үйл ажиллагааг гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төвлөрсөн халаалтад шилжсэн Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль болон Бугат, Буянт сумын төсөвт байгууллагуудын галч нарын цалинг гэрээтийн цалингаар сургуулийн төсөвт суулгаж, санхүүжүүлж ирсэн байна.

Бугат сумын төсөвт байгууллагууд 2019-2020 онд галч нарын цалинд нийт 160.4 сая төгрөгийг, Буянт сумын төсөвт байгууллагууд 99.0 сая төгрөг, Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль 2018-2020 онд 117.7 сая төгрөгийг төсвөөс үр ашиггүй зарцуулсан байна.

Аудитын дүнгээр Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн халаалтын зардлын үнэ тарифыг дахин хянаж батлах, төвлөрсөн халаалтад шилжсэн байгууллагуудын галч нарын цалинг байгууллагын цалингийн зардлын төсөвт тусгаж төлөвлөж, санхүүжүүлж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж ирсэн зөрчлийг арилгах, галч нарыг тухайн компанид шилжүүлэн ажиллуулах талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь халаалтын зардлыг төлөвлөж, хуваарилахдаа Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” 337 дугаар тогтоолын 7-д “Орон нутгийн 2018 оны төсвийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай”, 7.3-т “орон нутгийн дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхгүй байх, төвлөрсөн халаалтад холбох, сумдын уурын зуухыг аймгийн төвийн уурын зуухтай нэгтгэн зохион байгуулахдаа төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх, сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын түлш, халаалтын зардлыг өр, авлага үүсгэхгүйгээр батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, хуваарилах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар санаачилга гаргаж ажиллаагүй байна.

Статистикийн хэлтсээс дизель түлш, нүүрсний үнийн 2017-2020 оны үнийн судалгааг авч үзэхэд:

Хүснэгт №7

мянган төгрөгөөр

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	Өсөлт/2017 ба 2020 он
Дизелийн түлш, 1 литр	1649.1	1954.7	2021.4	1878.6	13.92
Нүүрс 1 тонн	65969	69417	66944	72917	10.5

Эх сурвалж: Аймгийн Статистикийн хэлтсээс авсан мэдээлэл

2017-2020 онуудад дизель түлш, нүүрсний үнэ жил бүр тодорхой хэмжээгээр өсөж ирсэн ба 2017 онтой харьцуулахад 2020 онд дизель түлшний үнэ 13.9 хувиар, нүүрсний үнэ 10.5 хувиар нэмэгдсэн байна.

Энгийн халаалттай төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсөв нэмэгдэхэд дизелийн түлш, нүүрсний үнийн өсөлт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

1.1.3. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайг хянаж баталгаажуулаагүй байгаа тул үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй байна

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн шууд санхүүждэг болон сумын төсөвт байгууллагуудын халаалтын талбайн талаар нэгдсэн судалгаа, мэдээлэл байхгүй, төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүнийг мэргэжлийн байгууллагатай хамтран хянаж баталгаажуулаагүй байна. Байгууллагуудаас ирүүлсэн төсвийн төслийг хянахдаа сумын ажлын хэсгийн тогтоосон талбайн хэмжээг үндэслэж ирсэн байна.

2019-2020 онд Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг, Ногооннуур сумын 2 дугаар цэцэрлэг, Сагсай сумын 2 дугаар цэцэрлэг, Цэнгэл сумын 4 дүгээр цэцэрлэг, Өлгий сумын 19, 21 дүгээр цэцэрлэг, Өлгий сумын ЕБ-ын 10 дугаар сургууль зэрэг

байгууллагууд шинээр байгуулагдсан, 2018-2020 онуудад 18 төсөвт байгууллагын барилга байгууламж шинээр баригдаж шинэчлэгдсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс төсөвт байгууллагуудын халаалтын талбайд 2017-2020 онд нэмэгдсэн, хасагдсан өөрчлөлтийг хянаж баталгаажуулаагүй байгаа бөгөөд энэ талаар ямар нэгэн нотлох баримт ирүүлээгүй болно.

Аудитын явцад төсөвт байгууллагуудаас халаалтын талбайн эзлэхүүнд орсон өөрчлөлтийн талаар судалгаа авч нэгтгэж үзэхэд:

- 2017 онд төсөвт байгууллагуудын халаалтын талбайн хэмжээнд өөрчлөлт ороогүй, шинээр барилга байгууламж ашиглалтад ороогүй байна.

- 2018 онд Баяннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байр ашиглалтад орж халаалтын талбайн эзлэхүүн 3072 метр кубээр нэмэгдэж, гал тогоо шинэ дотуур байранд байрласан тул 759 метр кубээр буурсан, Бугат сумын ЭМТ-ийн 812 метр куб сургалтын байр, 138 метр куб гараажын халаалтын талбай нэмэгдсэн, Өлгий сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 12931.4 метр куб халаалтын эзлэхүүнтэй хичээлийн шинэ байр, Цагааннуур тосгоны Захирагчийн албаны халаалтын талбайд Цагдаагийн шинээр баригдсан постын халаалтын талбай нэмэгджээ.

- 2019 онд Алтай сумын Улаанхад бага сургуулийн 1352 метр куб шинэ хичээлийн байр, Булган сумын Ёлт сургуулийн шинэ хичээлийн байр, биеийн тамирын заал, Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 3816 метр куб 150 хүүхдийн дотуур байр ашиглалтад орсон, Дэлүүн сумын 2 дугаар цэцэрлэг байгуулагдаж 1 дүгээр цэцэрлэгийн хуучин байрыг шилжүүлсэн авч үйл ажиллагаа явуулж эхэлснээр 2615 метр куб халаалтын талбай нэмэгдсэн, Ногооннуур сумын 2 дугаар цэцэрлэг 3780 метр куб халаалтын талбайтай шинэ байранд орсон, Ногооннуур сумын Чихтэй бага сургуулийн биеийн тамирын заалны талбай нэмэгдсэн, Ховд бага сургуулийн хичээлийн шинэ байр баригдаж талбайн хэмжээ нэмэгдсэн, Улаанхус сумын Согоог багийн цэцэрлэгийн шинэ байр ашиглалтад орсноор халаалтын талбай нэмэгдсэн байна.

- 2020 онд Булган сумын Ёлт бага сургуулийн шинэ дотуур байр, Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2592 метр куб халаалтын талбайтай шинэ байр, Таван салаа бага сургуулийн 2362 метр куб халаалтын талбайтай шинэ байр, Улаанхус сумын Хөххөтөл сургуулийн 540 метр куб эзлэхүүнтэй хичээлийн шинэ байр, Цэнгэл сумын 4 дүгээр цэцэрлэгийн 3500 метр куб шинэ байр, Цагааннуур тосгоны дунд сургуулийн 240 хүүхдийн шинэ хичээлийн байр тус тус ашиглалтад орсон байна.

Аудитын явцад Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль өөрсдөө мэргэжлийн байгууллагад хандаж сургуулийн халаалтын талбайг тогтоож баталгаажуулсан хэмжилтийн зураг ирүүлсэн бөгөөд халаалт төлөх барилгын тэнхлэгийн хэмжилт 11967.63 метр куб байна. Халаалтын гэрээгээр халаалтын талбайн эзлэхүүн 12146 метр куб ба зөрүү нь 178.37 метр куб буюу 1300 төгрөгөөр тооцоход сард 231.8 мянган төгрөг, жилд 1855.0 мянган төгрөгийг халаалтын зардлыг илүү төлж байсан байна.

Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль 2017 оны 12 дугаар сараас 1300 төгрөгөөр халаалтын зардал тооцож төлж эхэлсэн тул 2018-2020 онд халаалтын талбайн зөрүүд илүү төлсөн 5.5 сая төгрөгийг “ТММН” ХХК-д төлөх халаалтын зардлаас суутгаж, төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Аудитын дүнгээр аймгийн Засаг даргад аймгийн ТЕЗ-ийн харъяа төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүнийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хянаж баталгаажуулах талаар зөвлөмж өгөө.

1.2 Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн зарцуулалт, гүйцэтгэл үр ашиггүй байна

1.2.1. Халаалтын зардлын төлөвлөлт үндэслэлгүй батлагдсанаас шалтгаалж зарим төсөвт байгууллагууд 2020 оны эцэст 416.6 сая төгрөгийн өртэй байна

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлээс үзэхэд түлш халаалтын зардал 2017 онд 6.1 сая төгрөгөөр хэтэрч 2018 онд 7.1 сая төгрөгөөр, 2019 онд 9.7 сая төгрөгөөр, 2020 онд 125.7 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Гэвч энэ нь бодит хэмнэлт биш юм.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нэгтгэсэн судалгаанаас үзэхэд 14 төсөвт байгууллага 2015 оноос хойш он дамжсан 416.6 сая төгрөгийн халаалтын зардлын өртэй байна.

Хүснэгт №8

сая төгрөгөөр

Аймгийн ТЕЗ-ийн харъяа төсөвт байгууллагуудын	Түлш халаалтын зардал			
	2017	2018	2019	2020
Төлөвлөгөө	4,079.9	4,616.3	4,871.6	5,258.6
Гүйцэтгэл	4,086.0	4,609.1	4,862.0	5,132.9
Зөрүү	(6.1)	7.1	9.7	125.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Түлш халаалтын зардлын гүйцэтгэлийг аймгийн шууд төсвийн байгууллагууд болон сумуудаар ангилж харуулахад:

Хүснэгт №9

сая төгрөгөөр

№	Нэр	Төлөвлөгөө				Гүйцэтгэл				Зөрүү			
		2017	2018	2019	2020	2017	2018	2019	2020	2017	2018	2019	2020
1	Аймгийн шууд	783.0	813.4	787.5	883.3	789.8	814.5	787.8	888.3	(6.9)	(1.0)	(0.3)	(5.0)
2	Алтай сум	98.4	261.6	210.8	277.8	98.4	261.6	210.9	270.4	-	-	(0.0)	7.4
3	Алтанцөгц сум	61.0	60.0	225.1	263.2	61.0	60.0	224.8	248.0	-	-	0.4	15.2
4	Баяннуур сум	97.9	100.7	218.1	257.9	97.7	100.7	217.1	251.7	0.3	-	1.0	6.2
5	Бугат сум	77.3	69.8	105.1	128.9	77.2	69.8	105.0	124.7	0.1	-	0.1	4.2
6	Булган сум	173.2	171.6	188.4	179.2	172.8	167.3	188.4	178.4	0.3	4.3	-	0.8
7	Буянт сум	69.8	73.9	93.7	107.2	68.9	74.0	94.5	106.2	1.0	(0.1)	(0.8)	1.0
8	Дэлүүн сум	306.2	324.9	351.0	350.4	306.6	324.8	348.2	355.5	(0.3)	0.2	2.8	(5.1)
9	Ногооннуур сум	77.8	79.0	99.9	94.5	77.8	79.6	99.3	96.1	-	(0.5)	0.6	(1.6)
10	Сагсай сум	185.2	187.2	197.1	267.4	184.1	186.7	184.5	265.8	1.1	0.5	12.6	1.6
11	Толбо сум	279.7	274.3	256.0	261.6	280.3	271.5	258.2	251.4	(0.6)	2.8	(2.2)	10.2
12	Улаанхус сум	364.4	331.3	339.4	338.7	363.3	330.1	327.4	250.0	1.1	1.2	12.0	88.7
13	Цэнгэл сум	370.5	374.1	351.2	344.3	373.0	374.1	368.2	348.8	(2.4)	-	(17.0)	(4.5)
14	Өлгий сум	1,102.6	1,456.5	1,383.1	1,428.4	1,102.3	1,456.6	1,382.4	1,425.5	0.3	(0.1)	0.7	2.9
15	Цагааннуур тосгон	32.9	38.0	65.1	75.8	32.9	38.0	65.3	72.1	(0.1)	-	(0.2)	3.7
	ДҮН	4,079.9	4,616.3	4,871.6	5,258.6	4,086.0	4,609.1	4,862.0	5,132.9	(6.1)	7.1	9.7	125.7

Эх сурвалж: Аудитын судалгаа

Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь дэргэдээ зуухтай, төвлөрсөн халаалтад холбогдоогүй, энгийн халаалттай боловч халаалтыг хариуцаж байгаа “ТММН” ХХК-д аймгийн Зохицуулах зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 14-ний

өдрийн 11 дүгээр тогтоолоор “Өлгий сумын 9 дүгээр багийн ЕБ-ын 5 дугаар сургуульд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийг 2017 оны 10 дугаар сарын 01-нээс 10 жилийн хугацаатай олгосон байна.

Өлгий сумын 14 дүгээр цэцэрлэг “Хүлэг ирээдүй” ХХК-иас дулааны эрчим хүчийг гэрээний дагуу авдаг ба төвлөрсөн халаалтын үнэ тарифаар 1300 төгрөгөөр халаалтын зардлыг төлж ирсэн байна.

Зохицуулах зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хэрэглэгчийн үнийг “ТММН” ХХК-д 1300 төгрөгөөр тогтоож өгсөн байна. Аймгийн Зохицуулах зөвлөлөөс тогтоосон халаалтын нэгжийн үнэ тарифт ажиллах хүчний зардал буюу галч нарын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тооцож оруулж тогтоосон байна.

Өлгий сумын ЕБ-ын 5 дугаар сургууль, 14 дүгээр цэцэрлэгүүдийн халаалтын үнэ тарифыг бусад сумуудын үнэ тарифтай харьцуулж үзэхэд сургууль, цэцэрлэгийн дэргэд байрласан зуухтай, зөвхөн тухайн байгууллагад халаалт өгдөг байгууллагын төсвийг нэгдсэн халаалттай сумуудтай адилтгаж өндөр үнэ тариф тогтоож, халаалтын зардлыг төлөвлөж, санхүүжүүлж ирсэн байна.

Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн халаалтын төсөв нь 2018 онд 57.6 сая төгрөг байсан бол 2019 оноос 87.6 сая төгрөг болж 52 хувиар нэмэгдсэн байна. Үүнээс үзэхэд энэ нь бусдад давуу байдал бий болгосон, төсвийн хөрөнгийг үр ашиггүй байдлаар төлөвлөж, санхүүжүүлсэн явдал гэж үзэх үндэстэй байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн дансанд бүртгэлтэй байсан халаалтын зуухны 2 тоосгон байрыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 113 дугаар тогтоолоор тус сургуулийн халаалтыг хариуцаж байсан “ТММН” ХХК-д худалдсан байна.

Тухайн халаалтын зуухны барилга байрлаж буй газар нь сургуулийн өмчлөлд байдаг газар бөгөөд сургуулийн халаалтын зуухны барилгыг худалдсан нь хууль бус шийдвэр байна.

Аудитын дүнгээр Өлгий сумын ЕБ-ын 5 дугаар сургууль, Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн халаалтын үнэ тарифыг нэгдсэн халаалтаар тооцож үндэслэлгүй өндөр үнэ тариф тогтоосон зөрчлийг арилгуулахаар Аймгийн Зохицуулах зөвлөлд, энэхүү үнэ тарифаар халаалтын төсвийг төлөвлөж, хуваарилж, санхүүжүүлж ирсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн Засаг даргад тус тус албан шаардлага хүргүүлэв.

Өлгий сумын ЕБ-ын 5 дугаар сургууль “ТММН” ХХК-д 2018-2020 онуудад 12146 метр куб халаалтын талбайд 1300 төгрөгөөр тооцож халаалтын зардалд 227.3 сая төгрөг, гэрээтийн цалинд 2018-2019 онд 1 сантехник, 6 галч, 2020 онд 1 сантехник, 8 галч ажиллуулсны цалин хөлсөнд нийтдээ 117.7 сая төгрөгийг сургуулийн төсөөс олгосон байна.

Эрчим хүчний яамны 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/2721 дугаар албан бичгээр халаалтын эхлэх, дуусах хугацааг өөрчлөхгүй байх, төсөвт байгууллагуудын халаалтын өр төлбөрийг барагдуулж, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д зааснаар “аймгийн Засаг дарга эрчим хүчний тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нутаг дэвсгэрийнхээ эрчим хүчний хангамжийн талаарх бодлого боловсруулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ” гэсэн заалтын дагуу сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл

ирүүлсэн боловч төсөвт байгууллагуудын халаалтын өр төлбөрийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Халаалтын өглөгтэй байгууллагын судалгаа.

Хүснэгт №10

сая төгрөгөөр

№	Төсвийн захирагч	Өглөг үүссэн он	Өглөгийн дүн
1	Ул.ЕБ-ын 2-р сургууль	2020	15.8
2	Ул. ЕБ-ын 3-р сургууль	2020	15.2
3	Цн. тосгоны ЕБ-ын сургууль	2020	3.9
4	Аймгийн Музей	2020	15.4
5	МҮОНРТ-ийн БӨ салбар	2020	2.9
Нийт дүн			53.2

Эх сурвалж:

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын санхүүжилтийг дутуу авснаас Улаанхус сумын ЕБ-ын 2 дугаар сургууль 15.8 сая төгрөгийн, 3 дугаар сургууль 15.2 сая төгрөгийн, Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой зардал хүрэлцээгүйгээс 3.9 сая төгрөгийн өглөгтэй, Шүүхийн шийдвэрээр аймгийн Музейн халаалтыг 15.4 сая төгрөгөөр дутуу төлж ирсэн гэсэн шийдвэр гарсны дагуу өглөг үүссэн, Орон нутгийн олон нийтийн радио, телевизийн халаалтын зардлын батлагдсан төсөв хүрэлцээгүйгээс 2.9 сая төгрөгийн өглөгтэй гарч 2020 онд эдгээр байгууллагууд нийт 53.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

1.2.2. Санхүү төрийн сангийн хэлтсээс халаалтын зардлын төсвийн гүйцэтгэлд үр нөлөөтэй хяналт тавьж ажиллаагүй байна

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст 2020 оны эцсийн байдлаар төсөвт байгууллагуудын халаалтын зардлын өр авлагын талаар нэгдсэн судалгаа байхгүй ба халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд үр ашигтай хяналт тавьж ажиллаагүй байна. Үүнээс шалтгаалж зарим төсөвт байгууллага 2015 оноос он дамжсан халаалтын өр төлбөртэй байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгээр 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 14 байгууллага халаалтын зардалд 416.6 сая төгрөгийн өглөгтэй байгаагаас 9 байгууллага халаалтын зардалд 2015-2019 онуудад үүссэн 363.4 сая төгрөгийн, 2020 онд шинээр үүссэн 53.2 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна.

Хүснэгт №11

сая төгрөгөөр

№	Төсвийн захирагч	Өглөг үүссэн он	Өглөгийн дүн
1	Дэ.ЕБ-ын 1-р сургууль	2017-2020	73.7
2	Ул.ЕБ-ын 1 дүгээр сургууль	2015-2020	71.0
3	Ул. Эрүүл мэндийн төв	2019-2020	2.6

4	Өл.ЕБ-ын 1-р сургууль	2017-2020	28.9
5	Өл.ЕБ-ын лаборатори 2 дугаар сургууль	2018-2020	92.2
6	ЕБ-ын лаборатори 3 дугаар сургууль	2018-2020	18.9
7	Өл. ЕБ-ын 4 дүгээр сургууль	2017-2018	31.0
8	Өл. ЕБ-ын 6-р сургууль	2018-2019	7.2
9	Хөгжимт драмын театр	2018-2020	37.9
Нийт дүн			363.4

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дэлүүн сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Улаанхус сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль, Улаанхус сумын Эрүүл мэндийн төв, Өлгий сумын ЕБ-ын 1, 2, 3, 4, 6 дугаар сургуулиуд, Хөгжимт драмын театр зэрэг байгууллагууд халаалтын зардалд 2015-2019 онуудаас он дамжсан нийт 363.4 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

Энэ нь сумуудын нэгдсэн халаалтын үнэ тарифыг өндөр тогтоож, тэр үнэ тарифаар халаалтын зардлын төсвийг төлөвлөж, хуваарилж, санхүүжүүлж Сангийн яамнаас баталсан халаалтын зардлын төсвийг үндэслэлтэй төлөвлөж, хуваарилж чадаагүйгээс он дамжсан өр төлбөр үүссэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн төсвийн төлөвлөлт хариуцсан нэгжийн хувьд аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст аймгийн төсөвт байгууллагуудын барилга байгууламж, халаалтын талбайн эзлэхүүний талаар мэдээллийн нэгдсэн сан байхгүй, үнэ тарифын тооцоо, түүний үндэслэл, дулааны эрчим хүчээр хангаж байгаа байгууллагуудын сонгон шалгаруулалт, төсөвт байгууллагуудын халаалтын зардлын өр, авлагын талаар мэдээлэлгүй, уулзалт хийхэд тодорхой хариулт өгч чадахгүй байгаа нь халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэлд үр нөлөөтэй хяналт тавьж ажиллаагүй гэж үзэх үндэстэй байна.

Аудитын дүнгээр Санхүү, төрийн сангийн хэлтэст төсөвт байгууллагуудын барилга, байгууламж, хянаж баталгаажуулсан халаалтын талбайн эзлэхүүн, түүний өөрчлөлтийн талаар нэгдсэн мэдээллийн сантай болох, үнэ тариф, түүний үндэслэл, дулааны эрчим хүчээр хангагч байгууллагуудын сонгон шалгаруулалт, төсөвт байгууллагуудын халаалтын зардлын өр, авлагын талаар мэдээллийн сан бүрдүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

БҮЛЭГ 2. ХАЛААЛТЫН ҮНЭ ТАРИФ, ГЭРЭЭ ҮНДЭСЛЭЛТЭЙ, ҮР АШИГТАЙ ХИЙГДЭЭГҮЙ БАЙНА

2.1.Аймгийн дулааны эрчим хүчний үнийг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа үр нөлөөгүй байна

2.1.1. Зохицуулах зөвлөл сумуудын халаалтын үнэ тарифыг үндэслэлгүй тогтоосон байна

Зохицуулах зөвлөл нь: Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3-т "Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх",

-Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 231 дүгээр тогтоолоор баталсан "цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тариф тогтоох аргачлал", 2019 оны 522 дугаар тогтоолоор баталсан "Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал"-ын дагуу халаалтын үнэ тарифыг тогтоох,

-Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д "тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах" гэж заасны дагуу мэдээллийн нэгдсэн сан бий болгож ажиллах үүрэгтэй.

Сумуудын төсвийн байгууллагуудын халаалтын үнэ тарифыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн ирүүлсэн үнэ, тарифын тооцоо, санал, зардлын гүйцэтгэл, техник, эдийн засгийн үзүүлэлтэд үндэслэн тогтоосон боловч дээрх аргачлалын дагуу үнэн зөв тооцож гаргаагүй, 1 метр куб талбайн үнэ тарифыг харилцан адилгүй тогтсоосон, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгож ажиллаагүй байна.

Аймгийн Зохицуулах зөвлөл аудитад шаардсан ирүүлбэл зохих мэдээллийг ирүүлээгүй тул аудитын явцад шаардлагатай баримт материалыг гаргуулан авч шалгахар очсон боловч албан хэргийн хөтлөлт хангалтгүй, замбараагүй байгаа нь зөвлөлийн ажил хангалтгүй байгааг харуулж байна. Зохицуулах зөвлөлийн баримт бичиг, албан хэрэг хадгалагдаж байгаа газарт өөр байгууллага байрладаг байна.

Сумуудын халаалтын үнэ тариф тогтоосон байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12

төгрөгөөр

№	Сумуудын нэр	Зохицуулах зөвлөлийн тогтоол		НӨАТ-гүй		Хэмжүүрээр тооцох 1 Гкал дулааны үнэ /төг/	Хэрэглээний халуун усны тариф /төг/
		огноо	дугаар	Үнэ тариф /м3-төг/	Үнэ тариф/м2-төг/		
1	Алтай	2017.08.01, 2020.12.18	№06, №13	1420	1420 /дотуур байр/		
2	Алтанцөгц	2017.08.01	№06	1320			

3	Баяннуур	2018.07.27, 2020.01.16	№07, №20/06	1376			
4	Бугат	2018.07.27	№08	1298	2170 /дотуур байр/	121416	2100
5	Буянт	2018.07.27, 2020.01.16	№09, №20/08	1370	2464 /дотуур байр/	124342	2250
6	Дэлүүн	2015.07.29, 2019.09.23	№05, №19/16	1180		82500	2250
6	Дэлүүн	2017.11.27	№12	1350			
7	Толбо	2017.11.14	№08	1350			
8	Сагсай	2018.08.27	№06	1320	2218 /дотуур байр/		
9	Улаанхус	2015.07.29, 2017.12.18, 2019.09.23	№05, №13, №19/16	1180	1350 /дотуур байр/	82500	2250
10	Цэнгэл	2017.11.14, 2017.12.18	№08, №13	1380	1420 /дотуур байр/		
11	Өл.ЕБ-ын 5-р сургууль	2017.11.27	№12	1300			
11	Өл.14-р цэцэрлэг	2017.11.27	№12	1300			

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн дотуур байрны халаалтын 1 метр куб талбайн үнэ тарифыг 1350 төгрөгөөр, сумын бусад төсвийн байгууллагуудын халаалтын 1 метр куб талбайн үнэ тарифыг 1180 төгрөгөөр, Улаанхус сумын төсвийн байгууллагуудын халаалтын 1 метр куб талбайн үнэ тарифыг 1180 төгрөгөөр, бусад сумуудад халаалтын 1 метр куб талбайн үнэ тарифыг 1298-1420 төгрөгийн хооронд тогтоосон байна.

Мөн энгийн халаалттай Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Хүүхдийн 14 дүгээр цэцэрлэгийн барилгын 1 метр/куб талбайн үнэ тарифыг нэгдсэн халаалтын адилаар үндэслэлгүй тогтоосон байна.

Аймгийн төвийн нэгдсэн халаалтад холбогдсон төсөвт байгууллагуудын 1 метр куб халаалт талбайн үнэ тариф 1430 төгрөг байгаа бөгөөд сумуудын 1 метр куб халаалт талбайн үнэ тарифыг 1180-1420 төгрөгийн хооронд тогтоосон байна.

Сумуудын төсвийн байгууллагуудын халаалтын үнэ тарифыг дээрх байдлаар үндэслэлгүй өндөр тогтоосноос Сангийн яамнаас тус аймагт халаалтын зардалд баталсан төсвийн хуваарилалт үндэслэлгүй хийгдэж, улмаар аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиуд 2017 оноос он дамжсан өртэй гарч төсвийн санхүүжилтийг үр ашиггүй хуваарилж зарцуулах боломжийг бүрдүүлсэн байна.

Аудитын дүнгээр сумуудын төсвийн байгууллагуудын нэгдсэн халаалтын үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан аргачлалын дагуу

бодит тооцоо судалгаанд үндэслэн сум бүрээр шинэчлэн тогтоох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон техник, эдийн засгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгож ажиллах талаар албан шаардлага хүргүүлэв.

2.1.2. Төсөвт байгууллагуудад халаалт өгөх хугацааг төсөвтэй уялдуулах шаардлагатай байна

Эрчим хүчний сайдын 2016 оны “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” 08 дугаар тушаалаар Баян-Өлгий аймгийн төсвийн байгууллагуудын халаалтын эхлэх, дуусах хугацааг тухайн оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, дараа оны 05 дугаар сарын 01-ны өдрөөр буюу 7 сараар тогтоосон байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсээс төсвийн байгууллагуудын халаалт өгөх хугацааг мөн 7 сараар тогтоож журмыг мөрдөж ажилласан байна.

Эрчим хүчний сайдын 2019-2020 онуудад “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” 2018 оны 109 дүгээр тушаалаар Баян-Өлгий аймгийн төсвийн байгууллагуудын халаалтын эхлэх, дуусах хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн, дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр буюу 8 сараар тогтоосон боловч төсвийн байгууллагуудын халаалт өгөх хугацаа батлагдсан төсвийн хуваарьт харилцан адилгүй байна.

Халаалтын улиралд гэрээ байгуулсан байдлыг 2019, 2020 оны байдлаар харуулахад:

Хүснэгт № 13

№	Байгууллагын нэр	Халаалт өгөх хугацаа /сараар/	
		2019 он	2020 он
1	Алтай сумын сургууль, цэцэрлэг	7	7
2	Алтай сумын Улаанхад бага сургууль	7	8
3	Алтай сумын ЗДТГ	8	8
4	Алтай сумын Соёлын төв, эмнэлэг	8	7
5	Алтанцөгц сумын сургууль	7	8
6	Алтанцөгц сумын цэцэрлэг	6	8
7	Алтанцөгц сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
8	Баяннуур сумын Цаган арал бага сургууль	7	6
9	Баяннуур сумын Цэцэгт бага сургууль	8	6
10	Баяннуур сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
11	Бугат сумын Соёлын төв	7	7
12	Бугат сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
13	Булган сумын ЗДТГ	8	8
14	Булган сумын Соёлын төв	7	6
15	Булган сумын Соёлын төв, Елт бага сургууль, эмнэлэг	7	8
16	Булган сумын цэцэрлэг	6	6
17	Булган сумын сургууль, Шүвтэр бага сургууль, Елт цэцэрлэг	6	8
18	Буянт сумын ЗДТГ, сургууль, эмнэлэг	8	8
19	Буянт сумын цэцэрлэг	7	8
20	Буянт сумын Соёлын төв	6	8
21	Дэлүүн сумын Соёлын төв	6	7
22	Дэлүүн сумын бусад төсвийн байгууллагууд	8	8

23	Ногооннуур сумын Соёлын төв	7	
24	Ногооннуур сумын Улаанчулуу бага сургууль	7	6
25	Ногооннуур сумын ЗДТГ	7	6
26	Ногооннуур сумын Ховд бага сургууль	8	7
27	Ногооннуур сумын Чихтэй бага сургууль	8	7
28	Ногооннуур сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
29	Сагсай сумын сургууль	8	8
30	Сагсай сумын цэцэрлэг	6	8
31	Сагсай сумын бусад төсвийн байгууллагууд	7	8
32	Толбо сумын төсвийн байгууллагууд	8	8
33	Улаанхус сумын цэцэрлэг, сургууль	7	8
34	Улаанхус сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
35	Цэнгэл сумын ЗДТГ, сургууль, 2-р цэцэрлэг	7	8
36	Цэнгэл сумын бусад төсвийн байгууллагууд	8	8
37	Цагааннуур тосгоны Соёлын төв	7	7
38	Цагааннуур тосгоны бусад төсвийн байгууллагууд	8	8
39	Өлгий сумын 5 -р сургууль, 8-р цэцэрлэг	6	8
40	Өлгий сумын 4 -р сургууль	6	7
41	Өлгий сумын 2-р 5 жилийн сургууль	8	6
42	Өлгий сумын 1,3 -р сургууль, 1-р цэцэрлэг	7	7
43	Өлгий сумын 4 -р сургууль	8	7
44	Өлгий сумын 2 -р сургууль	8	7
45	Хотгор сургууль	8	7
46	Өлгий сумын бусад сургууль, цэцэрлэгүүд	8	8
47	Өлгий сумын 1 -р цэцэрлэг	8	6
48	Өлгий сумын 6, 7, 8, 12, 15, 18-р цэцэрлэгүүд	8	7
49	БӨ аймгийн ЗДТГ	7	8
50	Номын сан	6	8
51	Аймгийн төвийн бусад төсвийн байгууллагууд	8	8

Эх сурвалж: Аудитын судалгаа

2019 онд 86 байгууллага халаалтын хугацааг 8 сараар, 28 байгууллага 7 сараар, 12 байгууллага 6 сараар тогтоосон байна.

2020 онд халаалт өгөх хугацааг 8 сараар тогтоосон 99, 7 сараар тогтоосон 21, 6 сараар тогтоосон 9 төсвийн байгууллага байна.

Иймд төсвийн байгууллагуудын халаалт өгөх, дуусах хугацааг “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” Эрчим хүчний сайдын журам болон батлагдсан төсөвт уялдуулан ижил хэмжээгээр тогтоож ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.2. Сумуудын нэгдсэн халаалтын сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна

2.2.1. Сумын төсөвт байгууллагуудыг нэгдсэн халаалтаар хангах байгууллагуудын сонгон шалгаруулалт хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна

Аудитын явцад сумуудын төсөвт байгууллагуудыг халаалтаар ханган нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулсан байдлыг шалгаж үзэхэд:

№	Сумуудын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-ийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дугаар	Тайлбар
1	Алтай	"Нур төрө" ХХК	2017.07.19	№01/2017.	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/
2	Алтанцөгц	"ТММН" ХХК	2017.07.31	№01/2017.	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/
3	Баяннуур	"Киели жүйрик" ХХК	2018.05.30	№01	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/
4	Бугат	"Ахниет" ХХК	2020.05.25	№12	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/
5	Буянт	"Акбейл" ХХК	2018.07.09	№ 18/07/09	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг даргатай гэрээ хийсэн/
6	Дэлүүн	"Жанат" ХХК	2017.09.15	ЭХА-065/14	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргатай гэрээ хийсэн/
6	Дэлүүн	"Ел арасан" ХХК	2011.12.29	№654	Аймгийн Засаг даргын 2011 оны 12-р сарын 29-ний өдрийн 654 дугаар захирамжаар шалгаруулалтад тэнцсэн
7	Толбо	"Агайын" ХХК	2016.03.03	01/2016.	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/
8	Сагсай	"Каде" ХХК			"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг даргатай гэрээ хийсэн/
9	Улаанхус	"Жанат" ХХК	2017.09.05	ЭХА-064/14	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргатай гэрээ хийсэн/
10	Цэнгэл	"Агайын" ХХК	2015.08.25	01/2015.	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Сумын Засаг даргатай гэрээ хийсэн/

11	Өл. ЕБ-ын 5-р сургууль	"ТММН" ХХК			"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг даргатай гэрээ хийсэн/
11	Өл.14-р цэцэрлэг	"Хүлэг ирээдүй" ХХК	2018.05.30	№02	"Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ" /Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай гэрээ хийсэн/

- Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Сагсай, Толбо сумуудын төсвийн байгууллагын халаалтыг аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргатай хийсэн "Шинээр төвлөрсөн халаалтын зуух барих, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны гэрээ"-гээр,

-Дэлүүн, Улаанхус сумын халаалтыг Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргатай хийсэн гэрээгээр,

-Цэнгэл сумын төсвийн байгууллагуудын халаалтыг сумын Засаг даргатай хийсэн гэрээгээр,

-Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль, Өлгий сумын 14 дүгээр цэцэрлэгийн халаалтыг аймгийн Засаг даргатай хийсэн гэрээгээр,

-Буянт сумын Ерөнхий боловсролын сургуулиас бусад төсвийн байгууллагуудыг аймгийн Засаг даргатай хийсэн гэрээгээр шууд гэрээ байгуулж, хэрэгжүүлж ирсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг зөрчсөн тул зөрчил арилгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

Сумын төсөвт байгууллагуудыг халаалтаар хангаж байгаа тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нартай "Байгууллага, аж ахуйн нэгжид дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ" байгуулж ажилласан боловч гэрээг жил бүр дүгнээгүй, холбогдох албан тушаалтанууд нь хяналт тавьж ажиллаагүй байна.

Гэрээнд талуудын эрх, үүргийн талаар оруулсан заалтуудад хариуцлага хүлээх, байгуулсан гэрээг жил бүр дүгнэх талаар тодорхой тусгаагүй байна. Гэрээнд тавигдах нөхцөлүүдийг тодорхой оруулаагүй байгаа нь гүйцэтгэгч компаниудад хариуцлага хүлээлгэх боломжгүй болох магадлалтай байна. Төсөвт байгууллагуудын халаалт нийлүүлэгч компаниудтай байгуулсан гэрээ нь нэг загвараар хийгдсэн байна.

2.2.2. Халаалтын үнэ тарифын мөрдөлт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна

Санхүү, төрийн сангийн хэлтсээс аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс халаалтын үнэ, тариф тогтоосон тогтоол, халаалт түгээх аж ахуйн нэгж,

байгууллагуудын хооронд хийсэн гэрээг үндэслэн төсвийн байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөж, хуваарилан аймгийн ИТХ-д оруулж батлуулж байгаа боловч үнэ тарифын мөрдөлт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Төсөвт байгууллагуудын халаалтын үнэ тарифын үндэслэл, гэрээний хэрэгжилтийн талаар дүн шинжилгээ хийгдээгүй, мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Аудитын дүнгээр Санхүү, төрийн сангийн хэлтэст төсөвт байгууллагуудын үнэ тарифын үндэслэл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Холбогдох байгууллагын санал:

МОНГОЛ УЛС
БАЙН-ӨЛНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
23120/07 ул. Сайм-Батмунхуу
Утас (976) 7042 2485 Факс (976) 7042 3633
E-mail: info@ba-darga.mn
http://www.ba-darga.gov.mn

2021.08.26 № 1-01/1078

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын
2017-2020 оны төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэл, үр
дүнд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн
талаар санал байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН

0105211684

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөх, хуваарилах бодлого чиглэл тодорхойгүй, халаалтын зардлын төлөвлөлт, хуваарилалт оновчгүй байна.
2. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайг хянаж баталгаажуулаагүй байгаа тул үндэслэлтэй эсэх нь тодорхойгүй байна.
3. Санхүү төрийн сангийн хэлтсээс халаалтын зардлын төсвийн гүйцэтгэлд үр нөлөөтэй хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Халаалтын зардлын төлөвлөлт үндэслэлгүй хийгдсэнээс төсөвт байгууллагууд 2020 оны эцэст 416.6 сая төгрөгийг өртэй гарсан байна.
5. Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс сумуудын халаалтын үнэ тарифыг үндэслэлгүй тогтоосон байна
6. Төсөвт байгууллагуудад халаалт өгөх хугацааг төсөвтэй уялдуулж төлөвлөөгүй байна.
7. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулдаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй байна.
8. Халаалтын үнэ тарифын мөрдөлт, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.БАУЫРЖАН ТАНАА:

1. Төсөвт байгууллагуудын халаалтын зардлыг төлөвлөх, хуваарилах бодлого чиглэлийг тодорхойлж ажиллах;
2. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүнийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хянаж, баталгаажуулах;

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ФЕСТИВАЛЬ ТАНАА:

1. Орон нутгийн төсвийн байгууллагуудын барилга, байгууламж, мэргэжлийн байгууллагаар хянаж баталгаажуулсан халаалтын талбайн эзлэхүүн, түүний өөрчлөлтийн талаар болон өр, авлагын талаар нэгдсэн мэдээллийн сантай болох, халаалтын үнэ тарифын үндэслэлд хяналт тавьж ажиллах;
2. Түлш халаалтын зардлын төсөв хянахдаа “Халаалтын улирал эхлэх, дуусах хугацааг тогтоох тухай” Эрчим хүчний сайдын журмыг мөрдөж ажиллах.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 03 өдөр -

Дугаар 4/18

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх” тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын 2017-2020 оны төлөвлөлт, хуваарилалт, гүйцэтгэл, үр дүн” сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Санхүү төрийн сангийн хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Бауыржан/-д зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмж, албан шаардлагыг статистик мэдээний бүртгэлд авч, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Д.Назгүл/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т даалгасугай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

D:\bichig hereg\2021\tushaal.doc

Баян-Өлгий аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга, тэргүүлэх
аудиторын *бад* оны
бад дугаар сарын *дс*-ны өдрийн
А.Б. тоот тушаалын хавсралт

8317144071
БЮА0074 9007245

/сая.төг/

№	Байгууллагын нэр	Төлбөрийн		Албан шаардлагын	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн Засаг дарга			2	377.1
2	Аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөл			1	
3	Өлгий сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургууль	1	5.5		
	ДҮН	1	5.5	3	377.1